



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Дэгдээхэй цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/54/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 38
танай -ны № -т

ДЭГДЭЭХЭЙ ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ч.БУМАНГЭРЭЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэгдээхэй цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэгдээхэй цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	84 501 882,49	82 106 596,85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	439 060,44	0,44
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	439 060,44	0,44
3121	Төгрөг	439 060,44	0,44
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	439 060,44	0,44
35	БАРАА МАТЕРИАЛ	84 062 822,05	82 106 596,41
351	Түүхий эд материал	79 811 502,05	80 378 436,41
35110	Тусгай зориулалттай материал	79 811 502,05	80 378 436,41
354	Хангамжийн материал	4 251 320,00	1 728 160,00
35410	Бичиг хэргийн материал	757 100,00	393 500,00
35420	Аж ахуйн материал	3 415 500,00	926 860,00
35460	Хүнсний материал	78 720,00	407 800,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2 316 140 731,74	2 272 645 629,56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2 316 140 731,74	2 272 645 629,56
392	Биет хөрөнгө	1 885 170 731,82	1 841 785 629,68
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 916 941 868,53	1 939 141 872,53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(97 163 843,76)	(145 992 432,36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	60 150 425,00	61 411 325,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40 190 500,08)	(45 710 081,50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	125 191 447,10	125 819 447,10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(79 758 664,97)	(92 884 501,09)
393	Биет бус хөрөнгө	430 969 999,92	430 859 999,88
39301	Програм хангамж	550 000,00	550 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(220 000,08)	(330 000,12)
39303	Бусад биет бус хөрөнгө	430 640 000,00	430 640 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2 400 642 614,23	2 354 752 226,41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2 400 642 614,23	2 354 752 226,41
51	Засгийн газрын хувь оролцоо	2 400 642 614,23	2 354 752 226,41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	430 640 000,00	430 640 000,00
512	Хуримтлагдсан үр дүн	646 739 390,05	600 849 002,23
51210	Өмнөх үеийн үр дүн	646 739 390,05	646 739 390,05
51220	Тайлант үеийн үр дүн	-	(45 890 387,82)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 323 263 224,18	1 323 263 224,18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2 400 642 614,23	2 354 752 226,41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	610 295 700,00	624 047 654,00

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12 030 300,00	26 320 554,00
120	Нийтлэг татварын бус орлого	12 030 300,00	26 320 554,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12 030 300,00	26 320 554,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12 030 300,00	26 320 554,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	598 265 400,00	597 727 100,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	560 032 300,00	557 849 000,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	560 032 300,00	557 849 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1 645 000,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	900 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	245 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38 233 100,00	38 233 100,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38 233 100,00	38 233 100,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	673 670 621,04	669 938 041,82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	673 670 621,04	669 938 041,82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	661 208 027,29	665 515 050,49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	448 526 093,43	460 371 672,00
210101	Үндсэн цалин	311 406 540,43	269 157 179,00
210102	Нэмэгдэл	104 198 746,00	152 174 501,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	455 784,00	1 187 600,00
210104	Урамшуулал	32 465 023,00	37 852 392,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56 372 073,82	59 706 200,95
210201	Тэтгэврийн даатгал	38 990 414,28	41 761 844,05
210202	Тэтгэмжийн даатгал	4 511 849,31	4 767 213,43
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 582 599,85	3 662 570,73
210204	Ажилгүйдлийн даатгал	844 293,42	864 961,16
210205	Эрүүл мэндийн даатгал	8 442 916,96	8 649 611,58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28 658 229,00	32 288 335,72
210301	Гэрэл, цахилгаан	3 814 819,00	4 249 378,65
210302	Түлш, халаалт	20 733 516,00	24 280 808,39
210303	Цэвэр, бохир ус	4 109 894,00	3 758 148,68
2104	Хангамж, бараа материалын зардал	15 183 241,28	8 774 355,64
210401	Бичиг хэрэг	193 350,00	223 400,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	209 340,00	302 615,00
210404	Ном, хэвлэл	121 000,00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4 912 540,00	2 189 925,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5 564 300,00	2 904 300,00
210408	Бараа материал акталсны зардал	4 182 711,28	3 154 115,64
2105	Нормативт зардал	40 897 450,00	32 062 180,00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206 200,00	164 300,00
210502	Хоол, хүнс	39 623 650,00	31 397 880,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 067 600,00	500 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 050 000,00	2 055 200,00
210604	Урсгал засвар	2 050 000,00	2 055 200,00
2107	Томилолт, зочны зардал	-	80 600,00
210702	Дотоод албан томилолт	-	80 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8 600,00	1 122 800,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8 600,00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1 122 800,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69 512 339,76	69 053 706,18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2 639 700,00	1 469 700,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66 872 639,76	67 584 006,18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12 462 593,75	4 422 991,33
2132	Бусад урсгал шилжүүлэг	470 000,00	439 060,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	470 000,00	439 060,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7 524 871,00	3 889 564,28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7 524 871,00	3 889 564,28
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4 467 722,75	94 367,05
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4 467 722,75	94 367,05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(63 374 921,04)	(45 890 387,82)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3 986 800,00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3 986 800,00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3 986 800,00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(67 361 721,04)	(45 890 387,82)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430 640 000,00	1 323 263 224,18	646 739 390,05	2 400 642 614,23
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(45 890 387,82)	(45 890 387,82)

2021 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	430 640 000,00	1 323 263 224,18	600 849 002,23	2 354 752 226,41
---	----------------	------------------	----------------	------------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	600 217 526,00	598 537 010,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	600 217 526,00	598 537 010,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	560 032 300,00	557 849 000,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	560 032 300,00	557 849 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1 645 000,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	900 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	245 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38 233 100,00	38 233 100,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38 233 100,00	38 233 100,00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1 952 126,00	809 910,00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1 952 126,00	809 910,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	600 487 526,00	598 576 070,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	600 487 526,00	598 576 070,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	586 072 806,25	593 343 168,67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	448 526 093,43	460 371 672,00
210101	Үндсэн цалин	311 406 540,43	269 157 179,00
210102	Нэмэгдэл	104 198 746,00	152 174 501,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	455 784,00	1 187 600,00
210104	Урамшуулал	32 465 023,00	37 852 392,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56 372 073,82	59 706 200,95
210201	Тэтгэврийн даатгал	38 990 414,28	41 761 844,05
210202	Тэтгэмжийн даатгал	4 511 849,31	4 767 213,43
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 582 599,85	3 662 570,73
210204	Ажилгүйдлийн даатгал	844 293,42	864 961,16
210205	Эрүүл мэндийн даатгал	8 442 916,96	8 649 611,58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28 658 229,00	32 288 335,72
210301	Гэрэл, цахилгаан	3 814 819,00	4 249 378,65
210302	Түлш, халаалт	20 733 516,00	24 280 808,39
210303	Цэвэр, бохир ус	4 109 894,00	3 758 148,68
2104	Хангамж, бараа материалын зардал	7 314 230,00	2 206 000,00

210401	Бичиг хэрэг	193 350,00	294 800,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	209 340,00	302 615,00
210404	Ном, хэвлэл	121 000,00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6 442 340,00	1 300 485,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	348 200,00	308 100,00
2105	Нормативт зардал	39 746 780,00	33 017 660,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206 200,00	90 700,00
210502	Хоол, хүнс	38 472 980,00	31 726 960,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 067 600,00	1 200 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 050 000,00	2 055 200,00
210604	Урсгал засвар	2 050 000,00	2 055 200,00
2107	Томилолт, зочны зардал	-	80 600,00
210702	Дотоод албан томилолт	-	80 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8 600,00	1 122 800,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8 600,00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1 122 800,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3 396 800,00	2 494 700,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3 396 800,00	2 494 700,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14 414 719,75	5 232 901,33
2132	Бусад урсгал шилжүүлэг	2 422 126,00	1 248 970,00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1 952 126,00	809 910,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	470 000,00	439 060,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7 524 871,00	3 889 564,28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7 524 871,00	3 889 564,28
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4 467 722,75	94 367,05
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4 467 722,75	94 367,05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(270 000,00)	(39 060,00)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	400 000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	400 000,00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	400 000,00
223001	Бусад хөрөнгө	-	400 000,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(400 000,00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(270 000,00)	(439 060,00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		439 060,44
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	439 060,44	0,44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	596082100,00	592098168,67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	596082100,00	592098168,67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	596082100,00	592098168,67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	460396400,00	460371672,00
210101	Үндсэн цалин	256529300,00	269157179,00
210102	Нэмэгдэл	162108200,00	152174501,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4018200,00	1187600,00
210104	Урамшуулал	37740700,00	37852392,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59706300,00	59706200,95
210201	Тэтгэврийн даатгал	41280400,00	41761844,05
210202	Тэтгэмжийн даатгал	4606500,00	4767213,43
210203	ҮОМШӨ-ний даатгал	3685200,00	3662570,73
210204	Ажилгүйдлийн даатгал	921300,00	864961,16
210205	Эрүүл мэндийн даатгал	9212900,00	8649611,58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35948900,00	32288335,72
210301	Гэрэл, цахилгаан	7451600,00	4249378,65
210302	Түлш, халаалт	23336200,00	24280808,39
210303	Цэвэр, бохир ус	5161100,00	3758148,68
2104	Хангамж, бараа материалын зардал	1461000,00	1461000,00
210401	Бичиг хэрэг	157800,00	49800,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	127 800,00	302 615,00
210404	Ном, хэвлэл	98 700,00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	792 600,00	800 485,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	284 100,00	308 100,00
2105	Нормативт зардал	32 587 200,00	32 517 660,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90 700,00	90 700,00
210502	Хоол, хүнс	31 796 500,00	31 726 960,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700 000,00	700 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 284 200,00	2 055 200,00
210604	Урсгал засвар	2 284 200,00	2 055 200,00
2107	Томилолт, зочны зардал	80 600,00	80 600,00
210702	Дотоод албан томилолт	80 600,00	80 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 122 800,00	1 122 800,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 122 800,00	1 122 800,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2 494 700,00	2 494 700,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2 494 700,00	2 494 700,00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	596 082 100,00	591 659 108,67
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	557 849 000,00	557 754 632,95
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	557 849 000,00	557 754 632,95
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38 233 100,00	34 343 535,72
132001	Орон нутгийн төсвөөс	38 233 100,00	34 343 535,72
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	(439 060,00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	(439 060,00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		439 060,44
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0,44
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1,00	1,00
610001	Төсвийн байгууллага	1,00	1,00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42,00	42,00
620001	Удирдах ажилтан	1,00	1,00
620002	Гүйцэтгэх ажилтан	17,00	17,00
620003	Үйлчлэх ажилтан	24,00	24,00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	280,00	280,00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	280,00	280,00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	280,00	280,00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42,00	42,00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	27,00	27,00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	15,00	15,00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 645 000,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 245 000,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 245 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	745 000,00
210401	Бичиг хэрэг	245 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500 000,00
2105	Нормативт зардал	500 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500 000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	400 000,00
2200	Дотоод эх үүсвэрээр	400 000,00
223001	Бусад хөрөнгө	400 000,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1 645 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1 645 000,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	900 000,00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	245 000,00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Дэгдээхэй цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Дэгдээхэй цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Дэгдээхэй цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд тухайн нас бүрт нь таарсан боловсрол, өөрийгөө илэрхийлэх арга барил, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, суралцах таатай орчин бүрдүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Дэгдээхэй цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 625,900.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,259.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,381.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Дэгдээхэй цэцэрлэг нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,890.4 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	439.1	0.0	(439.1)
Бараа материал	84,062.8	82,106.6	(1,956.2)
Үндсэн хөрөнгө	2,316,140.7	2,272,645.6	(43,495.1)
Нийт хөрөнгө	2,400,642.6	2,354,752.2	(45,890.4)
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,400,642.6	2,354,752.2	(45,890.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,400,642.6	2,354,752.2	(45,890.4)

Бараа материалын дансны үлдэгдэл 82,106.6 мянган төгрөг болж өмнөх оныхоос 1,956.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны бараа материалын зарцуулалт болон 3,154.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал актласантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,272,645.6 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 43,495.1 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын хэмжээнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,354,752.2 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 45,890.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн Дэгдээхэй цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 655,347.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 655,347.7 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийг 2 удаа тодотгол хийж 31,300.0 мянган төгрөгөөр бууруулж, 624,047.7 мянган төгрөгөөр баталжээ. Хоолны зардлыг бууруулж тодотгол хийсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх СӨБ-ын арга хэмжээг хэрэгжүүлэхээр 557,849.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 38,233.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, нэмэлт санхүүжилтаар 1,645.0 мянган төгрөгөөр санхүүжүүлж, урсгал үйл ажиллагаанд 593,743.1 мянган төгрөгийг зарцуулж, 94.4 мянган төгрөгийг улсын төсөвт, 3,889.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 592,098.2 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,660.6 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 229.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БОАЖГ-аас бүх нийтээр мод тарих хаврын ажлын шагналд 900.0 мянган төгрөг, БСУГ-аас ариутгал халдваргүйтгэлийн зардалд 500.0 мянган төгрөг, тендер зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой орлого 245.0 мянган төгрөгийг тус тус нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 245.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд, нормын хувцас зөөлөн эдлэл 500.0 мянган төгрөг, ариутгал халдваргүйтгэлийн зардалд 500.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 400.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дэгдээхэй цэцэрлэг нь 2021 онд нийт 673,924.8 мянган төгрөгийн 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 673,924.8 мянган төгрөгийн 135 мэдээллийг ил тод байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг хангаж ажиллаагүй шилэн дансны хуулийн хугацааг хоцроосон байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,745.7 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт, 4,600.0 мянган төгрөгийн албан шаардлагын биелэлтийг 100 хувьтарй хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Албан шаардлага	1	4,600.0	1	4,600.0			
Зөвлөмж	2	3,745.7	2	3,745.7			
Нийт дүн	3	8,345.7	3	8,345.7			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 29,341.0 мянган төгрөгийн материаллаг бус алдаа зөрчил илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд залруулсан алдаа гараагүй байна.

4.2 Албан шаардлага

Тайлант онд гарсан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээгүй болно.

4.2 Акт

Тайлант онд гарсан алдаа зөрчилд акт хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд мэдээлэх 147 талбарын мэдээллийн 137 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 10 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Шилэн дансны тухай 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “ Шилэн дансны мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол , шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтыг мөрдөөгүйтэй холбоотой байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлж, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хариуцлагыг сайжруулах.

2. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа 35 нэр төрлийн 29 341.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Уг хөрөнгүүдийг ашиглагдаж байгаа, акталж устгахаар нь ангилж ялгаагүй байгаа ба УСНББОУС үндсэн хөрөнгө 17-г баримталж ажиллаагүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Үлдэх өртөггүй болсон хөрөнгийг дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргуулан дахин үнэлгээг хийлгэн санхүүгийн тайланд тусгаж байх. Мөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг заавар журмын дагуу актлуулах саналыг гаргуулан актлаж устгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн нэгтгэл		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Дэгдээхэй цэцэрлэг	2	29,341.0							2	29,341.0
Нийт		2	29,341.0							2	29,341.0

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ийн ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:



Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:




Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:




6117143690
ΦΑΑ0073 9042808

Ц.НАРМАНДАХ